



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 02 өдөр

Дугаар А/166

Улаанбаатар хот

Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсэд  
байгаа малыг нүүлгэн шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоол, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн орон сууц, суурьшлын бүсчлэлд мал аж ахуй эрхлэлтийг эмх цэгцтэй болгох, хүн, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх талаарх бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд дүүргийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд байгаа иргэдийн малыг холбогдох хууль, журмын дагуу нүүлгэн шилжүүлэх ажлыг 2023 оны 08 дугаар сарын 03-ны өдрөөс 09 дүгээр сарын 29-ний өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Мал нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


3. Захирамжийн хэрэгжилтийг ханган тайлан мэдээг 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор танилцуулахын Ажлын хэсэг (Б.Болормаа)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2023 оны 08 дүгээр сарын 02 ны өдрийн  
А/166 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт




### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Болормаа	Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч
Гишүүд:	Ч.Магадсайхан	Газар зохион байгуулалтын албаны дарга
	Т.Лхагвасүрэн	Цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа
	Б.Цогбадрах	Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа
	Б.Гэрэлмаа	Багахангай тохижилт ОНӨААТҮГ-ын дарга
	Я.Батсүх	Мал эмнэлгийн тасгийн дарга
	Н.Нямзав	1 дүгээр хорооны Засаг дарга
	Б.Батзориг	2 дугаар хорооны Засаг дарга
Нарийн бичгийн дарга:	Э.Юмжирмаа	Хөдөө аж ахуйн тасгийн дарга



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2023 оны 08 дүгээр сарын 08 ны өдрийн  
1166 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



МАЛ АЖ АХУЙ ЭРХЛЭХИЙГ ХОРИГЛОХ БҮСЭД БАЙГАА МАЛЫГ  
НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Зохион байгуулах арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
1	НИТХ-ын 2023 оны 62 дугаар тогтоолын дагуу мал аж ахуй эрхлэхийг хориглох бүс, хил хязгаарт байгаа малчин, мал бүхий иргэдэд мэдээлэл хүргэх ажил	2023.08.03- 2023.08.18	Хороод
2	Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүс, хил хязгаарт байгаа малчин, мал бүхий иргэдийн нарийвчилсан судалгаа гаргах	2023.08.21- 2023.08.22	Хороод, Хөдөө аж ахуйн тасаг,
3	Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсэд байгаа малыг нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөө гарган батлуулах	2023.08.23- 2023.08.25	Газар зохион байгуулалтын алба, Хөдөө аж ахуйн тасаг, Хороод,
4	Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсэд байгаа малыг нүүлгэн шилжүүлэх ажлын төсөв тооцоог гаргах	2023.08.25	Газар зохион байгуулалтын алба, Мал эмнэлгийн тасаг, Хөдөө аж ахуйн тасаг,
5	Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсэд бэлчээсэн мал, амьтныг хашиж, эздэд нь хариуцлага тооцох журам боловсруулах	2023.08.03- 2023.08.28	Газар зохион байгуулалтын алба ,Мал эмнэлгийн тасаг ,Хороод , Цагдаагийн хэлтэс , Онцгой байдлын хэлтэс , Багахангай тохижилт ОНӨААТҮГ
6	Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсэд байгаа малыг нүүлгэн шилжүүлэх ажил	2023.08.28- 2023.09.22	Газар зохион байгуулалтын алба ,Мал эмнэлгийн тасаг ,Хороод , Цагдаагийн хэлтэс , Онцгой байдлын хэлтэс , Багахангай тохижилт ОНӨААТҮГ
7	Суурьшлын бүсээс малаа гаргасан малчин, мал бүхий өрхүүдийн хашаа саравчийг буулгуулах, хог, өтөг бууцыг цэвэрлүүлэх, малын хашаа хороонд ариутгал, халдваргүйтгэл хийх	2023.08.28- 2023.09.22	Мал эмнэлгийн тасаг, Хороод, Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
8	Хориглосон бүсэд байгаа малчин, мал бүхий иргэдийг нүүлгэн шилжүүлсэн талаарх нэгдсэн тайлан мэдээг гарган танилцуулах	2023.09.22- 2023.09.29	Газар зохион байгуулалтын алба ,Мал эмнэлгийн тасаг ,Хороод , Цагдаагийн хэлтэс , Онцгой байдлын хэлтэс , Багахангай тохижилт ОНӨААТҮГ